

## СУМДЫН ЗАСАГ ДАРГА, ТҮҮНИЙ ТАМГЫН ГАЗРЫН 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНД ХИЙСЭН ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

### **Нэг.Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго**

Монгол улсын Засгийн газар болон аймгийн Засаг даргын Тамгын газраас боловсруулан баталсан бодлогын зорилтын хэрэгжилтийг хангуулах, нутгийн захиргааны байгууллагын удирдлагын манлайллыг хангах, чадавхыг сайжруулах, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, сайн туршлагаа хуваалцах, харилцан суралцах, иргэд олон нийтийг мэдээллээр хангаж цаашид авч хэрэгжүүлэх санал зөвлөмж өгөхөд оршино.

### **Хоёр.Хяналт-шинжилгээ, үнэлгээний үндэслэл, арга зүй**

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, Захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Аймгийн Засаг даргын 2017 оны А/452 дугаар захирамжаар баталсан Сумдын Засаг дарга, Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний газар, хэлтэс, агентлагуудын тухайн жилийн үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын дагуу сумдын Засаг дарга, түүний Тамгын газрын 2022 оны жилийн эцсийн үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ үнэлгээ хийлээ.

Үйл ажиллагааны үр дүнг үнэлэхэд дараах баримт бичгүүдийг хамруулсан.

Үүнд:

#### **Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ болох:**

- Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт
- Аймгийн дэд хөтөлбөрийн хэрэгжилт
- Эдийн засаг нийгмийн хөгжлийн үзүүлэлт

#### **Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ болох:**

- Аймгийн Засаг даргаас сумын Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт
- Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт
- Төрийн албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт
- Үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтийн биелэлт

#### **Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ болох:**

- Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын үнэлгээ
- Төсөв, санхүүгийн үйл ажиллагаа, шилэн данс хөтлөлтийн үнэлгээ

#### **Аймгаас дэвшүүлсэн зорилт, тусгайлан оруулсан заалтын хэрэгжилтийн үнэлгээ**

- Хүний хөгжлийг дэмжих жилийн хэрэгжилт
- Аймгаас тусгайлан оруулсан 9 заалтын хэрэгжилт зэрэг 11 үзүүлэлтүүдийг хамруулсан.

Журамд заасны дагуу нэгдсэн үнэлгээг тооцохдоо бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ болох 3 үзүүлэлтийн тайланг үзэж хамгаалуулахаас гадна илтгэлээр мэдээлэл сонсож үнэлгээ өгсөн.

Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ болох 3 үзүүлэлт, байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ болох 4 үзүүлэлт, байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ болох 2 үзүүлэлтийг ирүүлсэн тайлан болон холбогдох хэлтсүүдээс өгсөн үнэлгээ, газар дээр нь үзэж үнэлэх, статистик мэдээлэлд үндэслэн үнэлэх зэргээр, 4 дэх үзүүлэлт болох хүний хөгжлийг дэмжих жилийн ажлын хэрэгжилт, аймгаас тусгайлан заасан 9 арга хэмжээний хэрэгжилтийг сумдын Засаг даргын илтгэлийг сонсон ажлын хэсэг үнэлгээг өгсөн болно.

Эдгээр үзүүлэлтээс шилэн дансны хөтлөлтийн үнэлгээг Санхүү төрийн сангийн хэлтсээс, Аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний хэрэгжилт болон байгууллагын ил тод байдлын үнэлгээг Төрийн захиргааны удирдлагын хэлтсээс гаргасан үнэлгээгээр тооцсон болно.


### **Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн, дүгнэлт, зөвлөмж**

Байгууллагын үйл ажиллагааг үнэлэх үзүүлэлт тус бүрт хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний танилцуулга, дүгнэлт зөвлөмж:

#### **1. Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ:**

- **Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх тухайн жилийн төлөвлөгөөний биелэлт**

Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлсэн үнэлгээ болон тус хөтөлбөрт явцын хяналт шинжилгээ хийж, өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийн үнэлгээтэй харьцуулан тооцож дүгнэсэн болно.



**Дүгнэлт, анхаарах асуудал:** Сумдын засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн дундаж 86,1 хувьтай хэрэгжсэн байна.


Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд үнэлгээ хийхдээ урьдчилсан тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн дагуу зорилт, арга хэмжээг 6.2.1-т заасан арга зүйгээр үнэлэх бүрэн боломжтой байсныг 6.2.2-т заасан арга зүйгээр буюу зорилт, арга хэмжээний хүрсэн түвшинг тоо болон чанараар илэрхийлэх боломжгүй үед хэрэглэдэг арга зүйг нийтлэг ашигласан байна. Мөн шалгуур үзүүлэлт бүрийг үнэлсэн, хөтөлбөрийн хэрэгжилтийн дундаж хувийг гаргахдаа арга хэмжээний дундажаар гаргасан зэрэг нийтлэг алдаанууд давтан гаргаж байгаад анхаарах хэрэгтэй.

Цаашид хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг журмын дагуу үнэлж, нотлох баримт, тайлангийн танилцуулгын хамт гаргаж, сумын ИТХ-аар хэлэлцүүлэн, үнэлгээг тоон утгаар дүгнүүлсэн байх

Явцын хяналт-шинжилгээ хийгээд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах

- **Аймгийн дэд хөтөлбөрийн хэрэгжилт**


**Дүгнэлт, анхаарах асуудал:** “Хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр” болон “Дундговин ногооруулья” хөтөлбөрийн хэрэгжилтийг газар дээр нь үзэж хоёр хөтөлбөрийн хэрэгжилтийн дундажаар тооцож үнэлгээг гаргалаа.



Дэд хөтөлбөрийн сумдын үнэлгээний дундаж 87 хувьтай хэрэгжсэн байна. Цаашид дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх жил бүрийн төлөвлөгөө гарган, үр дүнг ажил хариуцсан мэргэжилтний гүйцэтгэлийн үнэлгээнд оруулж хагас бүтэн жилээр тооцож байх

- **Эдийн засаг нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлт**

**Дүгнэлт, анхаарах асуудал:** Засаглалын болон нийгэм эдийн засгийн хөгжлийн үзүүлэлтийг шалгуур үзүүлэлтийн дагуу гаргуулж газар дээр нь үнэлж дүгнэсэн. Сумдын үнэлгээний дундаж 87 хувьтай хэрэгжсэн байна.



Эдийн засаг нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн тайланг үзүүлэлт бүрээр өмнөх жилийн үнэлгээтэй харьцуулан үнэн зөвөөр тайлагнаж хэвших, Эдийн засаг нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн тайланг улирал бүр гарган өсөлт, бууралтад дүгнэлт хийж холбогдох байгууллагуудын ажлыг эрчимжүүлэх

## 2. Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ болох:

- **Аймгийн Засаг даргаас сумын Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт**  
Аймгийн Засаг даргаас сумын Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн хэрэгжилтийг үнэлэхдээ хэлтсүүдийн дүгнэсэн үнэлгээг шууд хэрэглэв.




**Дүгнэлт, анхаарах асуудал:** Аймгийн Засаг даргаас сумын Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн хэрэгжилтийн дундаж 85,4%-тай хэрэгжсэн байна.

Аймгийн Засаг даргаас сумын Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн хэрэгжилтийг гаргахдаа арга хэмжээний өөрийн үнэлгээг хоосон орхих, хугацаа болоогүй гэсэн нэр томъёо ашиглах, шалгууруудыг нэгтгэж бичих, арга хэмжээний хэрэгжилтийг гаргахгүй орхиж нэгтгэдэг зэрэг байдал гаргахгүй байхад анхаарч ажиллах

- **Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт**


**Дүгнэлт, анхаарах асуудал:** Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тооцохдоо төрийн 5 байгууллагын гэрээг сумын Засаг дарга үнэлж баталгаажуулсан үнэлгээг шууд хэрэглэв. Сумын төрийн 5 багууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт 88,8%-тай үнэлэгдсэн байна.



Цаашид гүйцэтгэлийн төлөвлөгөөний үр дүнг тооцохдоо төлөвлөлт, тайлагналтын чанарыг харгалзан үнэлгээг бодитой өгөх шаардлагатай байна.

- **Төрийн албан хаагчийн сургалт, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилт**  
**Дүгнэлт, анхаарах асуудал:**


Төрийн албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлтийг журмын хавсралтын дагуу хууль тогтоомжийг үнэлэх шалгуураар 2 төлөвлөгөөний дундажаар, 5 байгууллагын нийт үнэлгээг дундажлан тооцсон. /2 төлөвлөгөөний хэрэгжилтийн дундаж хувь/ Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний сумдын дундаж 90,6 хувьтай хэрэгжсэн байна.



Аймгийн “Хүний нөөцийг хөгжүүлэх” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хагас бүтэн жилээр тооцож тайланг Төрийн захиргааны удирдлагын хэлтэст 6, 11 сарын 10-ны дотор тайлагнах.

Төрийн албаны тухай хуулийн 55.3-ын дагуу байгууллага бүр төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг боловсруулан баталж, үр дүнг хагас бүтэн жилээр тооцож байх

• **Үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтийн биелэлт**



Үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтийн биелэлтийг газар дээр нь үзэж АЗДТГ-ын хэлтсүүдийн төлөөлөл үнэлгээ өгсөн. Сумдын үнэлгээний дундаж 80,4 хувьтай байна.

Агуулга		Сайнцагаан	Дэлгэрцогт	Адаацаг	Баянжаргалан	Говь-угтаал	Цагаандэлгэр	Дэрэн	Өндөршил	Гурвансайхан	Өлзийт	Сайхан-овоо	Эрдэнэдалай	Луус	Дэлгэрхангай	Хулд
Хяналт-шинжилгээ, үнэлгээ	ХШҮХ-т зөвлөмжийн хэрэгжилтийг хугацаанд нь ирүүлсэн байдал /5 оноо/	5	5	0	5	5	3	3	5	5	3	5	5	5	5	3
	Зөвлөмжийн хэрэгжилтийн хувь /15 оноо/	14.7	13.5	0	12.7	13.6	12.6	12	12.3	12.7	12.3	13	13.8	12.6	13	11.8
Төрийн захиргааны удирдлагын хэлтэс	Иргэдээс ирүүлсэн санал хүсэлт, өргөдөл гомдол шийдвэрлэлт /10 оноо/	9	9,5	8	7	6	9	3.5	10	10	6	8	9	8	2	8,6
	Ирсэн явсан бичгийн бүртгэл, шийдвэрлэлт /15 оноо/	9	14,5	13,5	4,5	9	12,2	12	6,4	10,8	3	12	13	12,5	6,6	13,7
	Фэйж хуудас /15 оноо/	14,4	15	9,6	13,7	11,8	6,6	13,3	12	10,9	11,5	13,5	15	11,4	12,3	15
	ERP ашиглалт /10 оноо/	8	10	6,5	9	10	5	5	7,5	8	10	9,5	10	10	7,5	7,5
	Төрийн албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлан /15 оноо/	12,1	9,7	10,2	9,2	9,2	9,2	6,7	11	8,2	10,9	9	14,3	12,1	12,7	14
Хууль, эрх зүйн хэлтэс	Хууль, эрх зүйн ажлын чанар хүртээмж /13 оноо/	12	13	6	8	12	9	7,5	10	5,5	7	11,5	10,5	11,5	8	10,5
	Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль тогтоомжийн хэрэгжилт /13 оноо/	12,5	13	10,5	6	12	11	13	12,5	11	11,5	13	13	9,5	12	10

	Албан хэрэг хөтлөлт, баримт бичгийн стандарт болон түүнтэй холбогдон гарсан эрх зүйн актын хэрэгжилт /15 оноо/	10,5	12	14	10	9	15	10	14	15	6	11,5	14,5	13	12	11,5
	Архивын нэгдсэн тоо бүртгэлийн мэдээллийг хүргэсэн байдал /5 оноо/	2,5	5	0	0	0	0	0	0	5	0	0	0	0	5	0
Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс	2022 оны Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны гүйцэтгэл, төсвийн талаар олон нийтэд ил тод мэдээлж буй байдал /38 оноо/	34,8	38	37	36	36	35	38	38	36	35	37	35	37	35	36
	Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны төлөвлөгөө баталсан байдал /20 оноо /	20	18	19	18	17	17	19	20	13	13	18	20	20	16,7	18,1
	Хоршоо хөгжүүлэх сангийн үйл ажиллагаа, гүйцэтгэлийн байдал /15 оноо/	15	14,5	15	14	9	7	9	12	10	12	13,5	13		15	11
Нийгмийн бодлогын хэлтэс	Сумын нийт иргэдийн эрт илрүүлэг оношилгооны хамрагдалт /10 оноо/	8,2	2	3,4	5,5	4,6	4	3,8	8,9	6,1	3,4	4,4	5,7	5	6,7	5
	Сумын нийт өрхийн угийн бичиг хөтлөлтийн байдал /5 оноо/	5	5	4,9	2	1,3	5	2	4	5	4	3	4,8	3	4	2
	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх, оролцоог хангах сумын орон тооны бус дэд салбар зөвлөлийн 2022 оны төлөвлөгөө, түүний хэрэгжилт /5 оноо/	5	5	0	4	4,5	0	0	3	4,3	3,5	5	4,9	4	4,7	5
	Залуучуудын хөгжлийн зөвлөлийн 2022 оны төлөвлөгөө, түүний хэрэгжилт /5 оноо/	4,8	5	0	4	2,5	2,5	3,5	4	4	3,5	5	5	4	4,7	4
Үнэлгээний хувь		88,4	92,9	68,8	73,7	75,3	71,2	84,6	83,4	78,8	68	85,7	90,2	83,5	79,9	81,5

### Дүгнэлт, анхаарах асуудал:

**Хяналт шинжилгээ, үнэлгээний хүрээнд:** 2022 онд хяналт-шинжилгээ, үнэлгээний багаас өгсөн зөвлөмжийг Сайнцагаан сум хамгийн сайн хэрэгжүүлж ажилласан бол Адаацаг сум өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажлаагүй бөгөөд тайлангаа ирүүлээгүй байна.

Цаашид Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэс болон хяналт шинжилгээ, үнэлгээний багаас өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх талаар санал санаачлага гарган ажиллах шаардлагатай байна. Өмнө нь өгсөн зөвлөмжийг дахин давтан гаргахгүй байх талаар удирдлага арга зүйгээр ханган, хяналт тавьж ажиллахыг сумдын удирдлагууд анхаарах хэрэгтэй байна.

### Нийгмийн бодлогын хүрээнд:

- Эхийн эндэгдэлгүй байгаа нь сайшаалтай
- 0-17 нас хүүхдийн эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалтын хувь тааруу
- Сумын нийт өрхийн угийн бичиг хөтлөлтийн хувь бага байна.

### Хууль эрх зүйн хүрээнд:

Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний тайлагналтыг нотлох баримттай тайлагнаж байх

Эрх зүйн сургалт, сурталчилгааг тогтворжуулж, эрх зүйн хөтөч нарын ажлыг загвар маягтын дагуу үнэлж дүгнэх

Удирдлагын эрх зүйн актаа улирал тутам цаг хугацаанд нь хянуулж, зөвлөмжийн хариуг хүргэж ажиллах

Архивын нэгдсэн тоо бүртгэлийн мэдээллийг маягтын дагуу гаргаж хугацаанд нь хүргэж ажиллах

Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон түүнд нийцүүлэн батлан гаргасан хууль, тогоомжуудын хэрэгжилтийг хангаж ажиллах

Хадгаламжийн сан буюу архивыг баримтын зориулалтын нягтруулсан шүүгээ болон тавиураар хангаж ажиллах

### **Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хүрээнд:**

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг төлөвлөхдөө Хөгжлийн бодлого, төлөвлөлт хөрөнгө оруулалтын тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоол, Орон нутгийн хөгжлийн сангийн журам, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоол, эрх зүйн актын хэрэгжилтийг ханган ажиллах

### **Төрийн захиргааны удирдлагын хүрээнд:**

Цаашид нэг албан тушаал дээр тогтвортой ажиллаж буй боловсон хүчний үзүүлэлтийг судалж ажиллах


Хүний нөөц бүрдүүлэлтэд судалгаа шинжилгээ гарган, дүгнэлт хийж ажиллах

Цахим шилжилтийн хүрээнд ERP цахим мэдээллийн системд ирсэн, явсан бичиг, иргэдээс ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл гомдлын бүртгэлийг хөтлөж, шийдвэрлэлтийг тухай бүр нь оруулж хэвшээгүй дутагдал нийтлэг гарч байгаа тул ERP цахим мэдээллийн системийн ашиглалтыг сайжруулах

## **3. Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ болох**

- Мэдээллийн ил тод нээлттэй байдал:**

Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын үнэлгээг 46 шалгуур үзүүлэлтийн дагуу аймгийн сайтад байршуулсан мэдээлэлд үндэслэн ТЗУХ-ээс өгсөн үнэлгээг шууд хэрэглэв.






### Дүгнэлт, анхаарах асуудал:

Мэдээллийн ил тод нээлттэй байдлын сумдын дундаж 55,3 хувьтай хэрэгжиж байна. Орон нутгийн онцлох ажлын мэдээ болон 46 шалгуур үзүүлэлтийн дагуух холбогдох мэдээллүүдээ цаг тухай бүрд нь бүрэн байршуулах.

### Төсөв, санхүүгийн үйл ажиллагаа ба шилэн данс хөтлөлт:

#### Дүгнэлт, анхаарах асуудал:



Аймгийн хэмжээнд сумдын төсөв санхүүгийн ажил 87,7 хувьтай хэрэгжиж байна.

Сумдын өмч хамгаалах зөвлөлийн ажил дутагдалтай ба өмчийн ашиглалт, хадагалалт, хамгаалалтад анхаарах шаардлагатай.

#### 4. Аймгаас дэвшүүлсэн зорилт, тусгайлан тусгасан 9 асуудал

Хүний хөгжлийг дэмжих жилийн ажлын хэрэгжилт болон аймгийн Засаг даргаас тусгайлан тусгасан 9 арга хэмжээний хэрэгжилтийг тухайн сумын Засаг даргын тавьсан илтгэлийн дүнгийн дунджаар тооцлоо.



**Дүгнэлт, анхаарах асуудал:** Сумдын үнэлгээний дундаж 84,9 хувьтай байна.

Хүний хөгжлийг дэмжих жил болон байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгайлан тусгасан арга хэмжээний хэрэгжилтийн тайланг гаргуулж, ажлын хэсгийн гишүүн тус бүр дээрх 2 асуудлын хүрээнд хийсэн ажил, илтгэл бэлтгэсэн байдал, илтгэх ур чадвар гэсэн шалгуур үзүүлэлтээр үнэлгээг өгч ажлын хэсгийн гишүүдийн дундаж үнэлгээгээр үнэлгээний дүнг гаргасан.

Аймгаас дэвшүүлсэн зорилтын хүрээнд хийх арга хэмжээг тусгай төлөвлөгөө боловсруулан, хэрэгжилт үр дүнгийн талаарх тайлан мэдээг тухайн зорилтыг хариуцан зохион байгуулах хэлтэст нотлох баримтын хамтаар тайлан мэдээний хуваарийн дагуу тайлагнаж байх

### **ДӨРӨВ. НЭГДСЭН ДҮГНЭЛТ**

Сумдын Засаг даргын Тамгын газар, түүний харьяа байгууллагуудын 2022 оны үйл ажиллагааны үр дүнг 11 үзүүлэлтээр үнэлж дүгнэн үнэлгээний дүнг Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулан аймгийн Засаг даргын 2023 оны А/140 дугаар захирамжаар үнэлгээний дүнг баталгаажуулж цаашид анхаарах асуудалд 16 заалт бүхий нийтлэг зөвлөмжийг гаргасан.

Үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээний дундаж 82,3 хувь, урьд онтой харьцуулахад 2,7 хувиар өссөн байна.

Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ 86,7 хувь, байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ 86.3 хувь, байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ 71.5 хувь, хүний хөгжлийн дэмжих жил болон байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгайлан тусгасан арга хэмжээний үнэлгээ 84,9 хувьтай байна. Үнэлгээний дүнгээр Эрдэнэдалай сумын Засаг даргын Тамгын газар тэргүүн байр, Дэлгэрцогт сумын Засаг даргын Тамгын газар дэд байр эзэлсэн бол 4 сумын Засаг даргын Тамгын газар дутагдалтай үнэлэгдсэн байна.

Мэдээллийн ил тод байдлын үзүүлэлтийг урьд онд 14 үзүүлэлтээр үнэлж байсан бол Засгийн газрын 2021 оны 374 дугаар тогтоолоор батлагдсан журмын 9 дүгээр хавсралтаар батлагдсан 46 шалгуур үзүүлэлтээр, шинээр нэмж дэвшүүлсэн зорилт болон байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний үнэлгээ зэргээр үнэлсэн нь урьд онуудаас ялгарах өөрчлөлт байлаа.

Үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтэд тухайн сум, байгууллагын дотоод чанартай үйл ажиллагаанаас сонгож жил бүр өөр шалгуур үзүүлэлтээр дүгнэдэг тул үүнд онцгойлон анхаарч үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлтийг ахиулж ажиллах нь зүйтэй.

Цаашид аймгийн Засаг даргын 2023 оны А/140 дугаар захирамжийн хавсралтаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган ажиллаж, тогтоосон хугацаанд хэрэгжилтийг ирүүлж, үйл ажиллагааны үр дүнгээ нэмэгдүүлэн ажиллахыг хүсье.

**ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС**